

“АРАБЫН ХАВАР” VS “ЛАЛЫН ХУВЬСГАЛ”

Д.Баярхүү*

Товч утга

Ойрхи Дорнод, Арабын ертөнц 2011 оны турш дэлхий нийтийг гайхшруулсан, одоо ч гайхшруулсаар байна. Бен Алийн, Мубаракийн, Каддафийн, Асадынхны, Салехын дэглэмүүд нурлаа, нурж байна. Арабын ба Персийн булангийн монархист орнуудад түүхэндээ улс төр-эдийн засгийн шинэчлэл хийгдэж байгаагүй, олон намын системийг ерөөсөө төлөвшүүлж байгаагүй (заримд нь бүр “А” ч байхгүй) ирснээс хэрэв дэглэм нурж, улс төрийн орон зай онгойвол цаашаа яах вэ гэдгээс үүдсэн гайхшрал, зарим талаар эргэлзээ ойрын ганц хоёр жил байтугай олон жилээр үргэлжлэхээр байна.

Дарангуйллын эсрэг боссон нь эргэлзээгүй

Дарангуйллын тогтолцооны эсрэг босч ирснээрээ тэртээх 1989-1990 оны поскоммунист хувьсгалыг нэг талаас санагдуулна. Нэгнээс нөгөөд хурдан халдварлаж байгаа байдал нь ч төстэй. Нийтлэг зүй тогтол дэндүү олон учраас тэр болов уу. Олон талаараа 1989-1990 оны Дорнод Европыг санагдуулам Арабын энэ хувьсгалыг ардчилсан, эсвэл өнгөт хувьсгал гэж шууд нэрлэхэд хэцүү. Лалын хувьсгал гэж албан ёсоор хэн ч нэрлээгүй. Гэвч хувьсгалын дүнд явуулсан бүх ард түмний сонгуулийн санал хураалтаар лалын нам хөдөлгөөнүүд хаалтгүй гарч ирж байгаа. Иймд хувьсгалыг оношлоход хэтэрхий эртдэнэ¹.

Үүнийг Египетээр жишээлж болно. Египет бол арабчуудын оюуны төв. Энэ орон тусгаар тогтнолоо 1952 онд тунхаглаад 2011 оны Арабын хавар-ыг хүртэл 4 төрийн тэргүүний нүүр үзэхдээ тэр дөрөв нь дөрвүүлээ цэргийн жанжид байснаас үүдэн дэглэм нурвал? гэсэн асуудал босч ирсэн ба 2011 оны гол дуулиан, оны хүн – Хосни Мубаракийн дэглэмийн уналтаар төлөөлүүлэн энэ ертөнцийн үнэн түүхийг харж болохоор юм. Египетчүүд орчин үеийн түүхэндээ

*Д.Баярхүү - Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин, Монгол Улсаас АБНУ-д суугаа, Саудын Арабын Вант Улс, ЛБНИУ-д хавсран суугаа Элчин сайдаар 2008-2012 онд ажиллаж байв. Энд хэвлэгдсэн нь албан ёсны байр суурийг тусгах албагүй. ШУА-ийн тус хүрээлэнгийн судлаач-профессорын судалгааны бүтээл болохыг анхаарна уу.

ердөө хоёр л хувьсгал хийсэн. Хоёулаа цэргийнхний оролцоотой, цэргийнхний хийсэн төрийн эргэлтийн үр дүнд хувьсгалууд нь ялсан. Цэргийн дээд элит гэдэг бол Египетийн нийгмийн локомотив байж ирсэн, байх ч ёстой. Тэд байхгүй бол тэдний орон зайг исламистууд л эзэлнэ, өөрөөр ямар ч хувилбар байхгүй. Улс төрийн эрх мэдэл бүхий улс төрийн хоёр л хүчин зэрэгцэн оршиж ирсэн. Эхнийх нь цэргийнхэн, хоёр дахь Лалын ахан дүүс гэх лалын хэт даврагч хөдөлгөөн байв.

Египетэд Насер, Садат, Мубарак нар л цэргийн хүчээр атгаад байсан болохоос Лалын ах дүүс гэх энэхүү бүлэглэл үнэндээ хамгийн хүчтэй. Өөр төрлийн тулгар үзэлт бүлэг намууд ч зарим нь ил, зарим нь нууцаар ажилладаг, тэдний нөлөө маш их байсныг тэмдэглэх хэрэгтэй. Мубарак унахад тэд л засаг авах илүү бололцоотой. Булаагаад ч, ардчилсан сонгууль явуулаад ч Египет тэднийх гэдгийг 2011 оны намар, 2012 оны хавар зун явуулсан сонгуулиуд ягштал харуулсан.

Гэхдээ энд нэг зүйлийг зориуд тэмдэглэх хэрэгтэй. Юу гэвэл Египетийн (цаашлаад нийт Арабын) ард түмэн шашнаар дутагдаж, гачигдаж, шашин нь хавчигдаж хориглогдож байсан тохиолдол нэгээхэн ч үгүй юм. Шашныг цэврээр мандуулах уриа лоозонгүй эхэлсэн энэхүү хувьсгалт үйл явц аажмаар шашны хувьсгал болон даамжирч, олон улсын шинжтэй болж, хувьсгалын үр дүнг исламистууд, жихадистууд, салафитууд илүү хүртэж тэдэнд ялалт авчирсаар буйг анхаарах хэрэгтэй.

Милитарист уламжлалынх нь парадокс

Цэргийнхэн нийгмийн локомотив байж ирсэн, байгаа нийтлэг үзэгдэл Сири, Ирак, Ливи, Йеменд яг ижил нэг зохиомж мэт харагддаг. Гамаль Насер нь домогт нисэгч Мубаракийг 1969 онд дэвшүүлэн гаргаж ирээд нисэх хүчнээ командлуулсан, 1972 онд нисэх хүчний маршал болгож шат ахиулсан, 1975 онд Ерөнхийлөгч Анвар Садат түүнийг Дэд ерөнхийлөгчөө болгож, 1981 онд Садат алагдахад цорын ганц орлогч нь болох маршал Мубарак орыг нь залгасан. Засгаа цэргийнхнээр бэхжүүлсэн. Нисэх хүчний маршалаас гадна хуурай замын цэргийн дээд цолыг ч хүртсэн.

Сирийн дарангуйлагч генерал Хафез Асад 1958 онд Сири Египеттэй нэгдэхэд Насераас нисэх хүчний дунд шатны тушаал хүртсэн, 1961 онд цэргийн эргэлт хийхэд оролцоод Египетээс хөөгдсөн. Сири эргээд тусгаар тогтносон. 1963 онд дахин цэргийн эргэлт дэгдэхэд Асад идэвхтэй оролцоод Засгийн газраа унагалцсан, шанд нь Сирийн нисэх хүчнийг захирах болж төд удалгүй Батлан

хамгаалахын сайд болсон. Цэргийнхний толгойд гарч ирсэн Асад 1970 онд дахин цэргийн эргэлт хийж өөрөө Ерөнхийлөгч болсон. Хүү Башар аль-Асадаа эмчийн мэргэжлээр суралцуулж эмч болгож байснаа хожим цэргийн академи дүүргүүлж хурандаа болгосон, тэрээр 2000 онд дэслэгч генерал цолтойгоор эцгээ залгамжлан төрийн эрхийг авсан.

1969 онд Ливийн хааныг 27-хон настай Муаммар Каддафи гэх бага тушаалын офицер цэргийн эргэлт хийж огцруулсан. Дарангуйлан захирснаараа бол Каддафи нь арабын бусад жолоодогчдоос хол давах (42 жил) ба Ливийн Арабын Ардын Аугаа их Социалист Жамахирия гэгч улсыг хамгийн тогтвортойгоор, албан ёсны ганц ч сөрөг хүчингүйгээр хурандаа Каддафи халаагүй захирсан.

Тунисын дарангуйлагч Бен Али бол мөн л цэргийн дээд элитийн төлөөлөл. Их бууч, цэргийн тагнуулч, чекист гээд цэргийн хосолсон олон мэрэгжилтэн, генерал цолтон. 1974 оноос цэргийн аюулгүй байдлын албаны дарга, БХЯ-ны канцелярын дарга, Үндэсний аюулгүй байдлын албаны дарга, Үндэсний аюулгүй төрийн нарийн бичгийн дарга, 1986 онд До яамны сайд, 1987 онд Ерөнхий сайд хийж яваад цусгүй эргэлтээр төрийн эрхийг авчээ. Арабын цэргийн жанжны хэвшмэл дүр болох энэ этгээд Арабын хавар-ын эхний давалгаанаар 2011 оны бүр эхэнд түлхэгдэн унасан юм.

Маршал Али Абдалла Салех гэх домогт эрийг Йеменчүүд 2011 оны турш элдэвлэн байж арай гэж буулгажээ. Ясны цэргийн тэрээр 1962 оны цэргийн эргэлтэд оролцож хаант засгийн түлхэн унагалцаж, иргэний дайнд оролцон баатар болж, цэргийнхнээр хүрээлүүлж; явсаар 1978 онд цэргийн эргэлтээр засгийн бүх эрхийг авчээ.

Цэргийн дээрх эрхтнүүд Каддафигаас бусад нь өөрийгөө, дэглэмээ хамгаалуулсан улс төрийн нам маягийн бүтэцтэй, тэр нь нам гэхээсээ хувийн, гэр бүлийн, кланы, цэргийнхний бүлэглэл маягтай. Египетэд Садат, Мубарак нарын эмхлэн байгуулсан Үндэсний ардчилсан нам, Сирид Арабын социалист сэргэн мандлын нам, Тунист Социалист дустур нам, Йеменд Ардын ерөнхий конгресс гэх мэт.

Нэгэнтээ цэргийн баялаг намтартай тэдний хувьд “түүхэн бие хүн” гэх ойлголт өөрөөр төлөвшсөн. Тэдний ойлголтоор бол лут мэргэн улс төрчийг ард түмэнд нь дээрээс заяадаг ба товойн гарч ирсэн нэгнээ нийгэм нь амьд бурхан адил тахин шүтнэ, тахин шүтлэгт нь хязгаар байхгүй, тахин шүтлэг нь ард түмнийх нь хувьд аз

жаргал нь байх ёстой. Парламент нь ганц нам буюу бүлгийн мэдэлд, ярсхийн гар өргөх депутатууд, Засгийн газар нь тэр чигтээ “түүхэн бие хүн” өөрөө. Иймд тэр гэдэг бол ердөө л ганц хүн, нийгэм бол ганц л баатар, өөр хэн ч үгүй. Гэхдээ ингэлээ гээд дэвшил бас байсан. Шашин-овог аймгийн зөрчил тэмцэлд идэгдсэн, хоцрогдсон ард түмнийг нэг тугийн дор зангидаж, нийгмээ тогтвортой авч явахад араб маягийн жолоодогчид түүхэн үүрэгтэй байж ирсэн.

Милитаристууд хувьсгалыг сөрөхүй

Дээрх жолоодогчид маань түүх өндөрлөж буйг эрүүл ухаанаар харж мэдэрч чадаагүй, чадах ч үгүй. Тэмцлийн эхэн үед тэдний гаргаж байсан ааш араншин туйлын ижил төстэй, бараг л үгссэн юм шиг. Хэлсэн үг нь огтоос буулт хийх шинжгүй, харин Засгийн газраа огцруулж байгааг зарласан, эх орноо хамгаалах уриа тунхаг бүхий, яльгүй өөлбөл туньсан, ашилж загнасан, буруушаасан маягийн үгс байв. Ганц хүний (өөрийнх нь) тахин шүтлэг нь ард түмнийх нь хувьд аз жаргал нь байх ёстой гэдгийг дахин ухуулж ятгасан шинжтэй.

Тэгснээ Ерөнхийлөгчийн албан тушаалд дахин нэр дэвшихгүй, албан тушаалаа үүрд орхих болно, гэхдээ засгийн эрхээ тайван замаар шилжүүлнэ, тайван амгалан эх орноо дараагийнхаа Төрийн тэргүүнд үлдээнэ. Сөрөг хүчний тавьж буй шаардлагын дагуу реформыг нэн даруй эхлүүлнэ, ядуурал, ажилгүйдэл, авилгалыг устгана гэсэн ам тангараг дагалдана. Албан тушаалаасаа шууд огцорчих аваас улс орон хаост орно гэж сэрэмжлүүлэхээ мартахгүй. Завсарт нь Нэр төртэй албаа өгнө чиг, нэр төртэй үхнэ чиг гэсэн Мубаракийн панфлет анхаарал татна. Төрийн албанд 62 жил зүтгэлээ. Надад хоргодох юм байхгүй, би явж болно. Гэхдээ би эх орноосоо хаашаа ч явахгүй² гэж хэлсээр тэрээр шоронгийн хаалга татсан юм.

Харин Каддафи бол эхнээсээ аваад эцсээ хүртэл шувтан заналхийлж сүрдүүлснээрээ бусдаасаа ялгаатай, тэр хэрээрээ ч нохойн үхлээр эх орондоо ясаа тавьсан. Ард түмнийхээ тэмцлийг цусан далайд живүүлээд өөрөө хамтдаа дуусая гэсэн андгай тангаргын үгс мөн ч олныг урсгасан. Би эндээ тулалдсаар байгаад үхэх үйлийн үртэй хүн, миний өвөг эцэг 1911 онд тэгж үхэж байсан үйлийн үртэн, би түүний араас орно, Надад хүч байх л юм бол би төрийн толгойд байх болно, түүнийхээ төлөө өөрийгөө золиход бэлэн байна. Ливийн дайснуудыг арчиж дуусгана, бүр нэг бүрчлэн, Тунис, Египетэд болсон шиг үйл явдал болно гэж битгий сана!³ гэх мэт цогтой үгсийг Каддафи хэлсээр өөрийнхөндөө алуулж, шарилаа доромжлуулсан

Лалжилтын парадокс

Арабын ертөнцийг хамарсан эрх чөлөөний эл хөдөлгөөн улам бүр лалжиж, зөвхөн Аллахыг ялуулахын төлөө болж хувирч байгаа нь тэр бүс нутгаас өдөр тутам ирэх мэдээллээс тодорхой болсоор байна.

- Египетэд исламист Ерөнхийлөгч нь төрийн дээд эрх мэдлийг эргэлтгүй авч буй;
- Радикал лалынхан хувьсгалын шуурганаар энд тэндгүй эрх чөлөөтэй болж буй;
- Хувьсгалын шуурганаар эгнэгт өндийсөн салафитууд бүс нутгаасаа халин нөлөөлж эхэлж буй;
- “Цоо шинэ Аль-Каеда” төлөвшин “Арабын хавар”-ыг чимж буй;
- Хийрхсэн исламистууд Ливид АНУ-ын Элчин сайдыг хөнөөсөн;
- Ливийн исламистууд Алжир руу халдаж, олон иргэнийг барьцаалсан ба алсан;
- Сирийн босогчид Израильтай хэзээ ч эвлэрэхгүйгээ андгайлж буй;
- Палестин-Израилийн хоорондын дайсагнал үргэлжилсээр буй зэргээс ажваас дээрх лалжилтыг өлхөн олж харахаар байна.

Мэдээж ардчилсан сонгууль явуулж, ард түмнээрээ төр засгаа сонгуулах нь хувьсгалын гол зорилго. Сонгууль шударгаар явууллаа гэхэд эцсийн үр дүнгээ үзтэл асар их холын зай туулахаар байгаа нь өнгөрсөн бүтэн жил хагасын турш харагдлаа. Ардчиллын ялалт нь эцэстээ засгийн эрхэнд радикал лалынхныг гаргаснаар өндөрлөх юм биш биз гэсэн хардлага, болгоомжлол өрнийн орнуудад, мөн Орост газар авч буй тухай мэдээлэл байнга цухалзана.

Дарангуйлагч дэглэмүүд нурдгаараа нурна, тэр бол жам ёсны үзэгдэл, гэвч тэр нуралтын дараа парламентын ба Ерөнхийлөгчийн сонгуульд исламист нам гэнэт ялаад гараад ирэх, ялалт байгуулж засгийн эрх авсан лалын тэр нам нь эдийн засаг-нийгмийн асуудлаа шийдэхийн тулд нийгмээ хүчээр лалжуулах вий гэдгээс хувьсгал хийсэн, хувьсгал нь үргэлжилж буй арабын тэр орнууд дахь иргэний, либерал намууд, нийгмийн зарим хэсэг, шашны цөөнх, эмэгтэйчүүд айж түгшиж буй тухай мэдээлэл хөвөрсөөр буй. Энэхүү түгшилтийг нотлох үйл явдлууд шил даран өрнөх ба Тунис, Египет, Ливи, Мароккод болж өнгөрсөн сонгуулиуд үүнийг аяндаа хэлээд өгнө.

“Арабын хавар” нь лалын контр хувьсгал болж хувирах

магадлал дэндүү өндөр байна. Өмнө нь хэн ч дурдаж, анхаарал хандуулж байгаагүй лалын шашны нэг урсгал – салафизм ба салафитууд гэгчийг дэлхийн нийтэд таниулж өгснөөрөө тэрхүү контр хувьсгалын нэг мөн чанар оршиж байх шиг. Ямар ч атугай олон улсын харилцаа, геополитикт салафитууд гэх хүчин зүйл баттай гарч ирлээ.

“Арабын хавар”-ын явцад улс төрийн тавцан дээр хоёр төрлийн исламистууд гарч ирсэн гэж үзэж болох юм. Үүнд 1) харьцангуй аядуу; 2) радикал салафитууд гэж. Аядуу гэдэг нь “харьцангуй” гэх тодотголтой, угаасаа радикал байснаа эл хувьсгалын явцад хэрсүүжин либеральчлагдаж байж болох талтай. Египет, Сири дэх “Лалын ахан дүүс”, Йемен дэх “Аль-Ислах” (Реформ хөдөлгөөн), Иордан дахь “Муназзама аль-амаль аль-Ислами” (лалын үйл ажиллагааны байгууллага), Тунис дэх “Ан-Нахда” (Сэргэн мандалт нам), эдэн дээр зарим судлаачид Газын зурвас дахь ХАМАС-ыг оруулж тооцсон байх нь бий. Харин хоёр дахь төрөлд багтах радикал хэсэг нь “Арабын хавар”-аас өмнө эх орондоо тас хориотой, экстремист, террорист хэмээн тооцогдож байсан египетийн “Ат-Такфир ва-ль-Хижра” (Үнэнч бус сүсэгтнийг цээрлүүлэх бүлэг), “Лалын Жамаат” (Аль-Жама’а аль-Исламийя), “Жихад” (Лалын ариун дайн) гэх мэт олон бүлэг, хөдөлгөөнийг нэрлэж болно. Эдний мянга мянган идэвхтэн гишүүд нь олон жил (олон арван) гянданд хоригдож, эсвэл эчнээ цааз сонсоод байсан ба зарим салафит, жихадистууд нь гадаадад цагаачлан, глобал жихадын фронтод (Афганистан, Босни, Чечень, Сомали гэх мэт) алба хашиж, зарим нь “Аль-Каида”-ын сургууль курсыг дамжин цаашаа “Талибан”, “Дорнод Туркестаны лалын хөдөлгөөн”, “Кавказын Имарат”-ад тулалдаж явсан, яваа аж⁴.

“Арабын хавар” ялах явцад хоёр зүйл тодорхой харагдлаа. 1) Радикал лалынхан эрх чөлөөтэй болж авлаа. Тэдний ихэнхийг шорон, гяндангуудаас хүчээр суллууллаа. Тэд ялгүй болж, өмнөх нүгэл хилэнц нь бүгд цагаадлаа. “Лалын ахан дүүс” холбоотонтой болж авлаа. Нийгэмд тэд хүчтэй байх, дараа дараагийн сонгуульд ялалт хангах нөхцлөө ийнхүү бүрдүүллээ. Ганц жишээ, Египетийн шинэ Ерөнхийлөгч Мухаммед Мурси албаа авмагц өнгөрсөн 7 дугаар сард 572 салафитад уучлал үзүүлсэн ба тэдний нэлээд нь цаазын ялтай сууж байсан. Тунист Бен Алийн дэглэмийг унагамагц 1208 салафитыг сулласан ба тэд ч мөн терроризмын эсрэг хуулиар шийтгэгдээд байсан юм. “Аль-Каида”-ын онолч Абу-Катадын (Омар Махмуд Осман) шавь Абу-Айяд гэгч алуурчин тэгэхэд суллагдсан, тэрээр Магриб, Афганистанд олон жил тулалдаж явсан

аж. 2) Хуулиас гадуур шийтгэлгүй дүрвэн нуугдаж явсан бүх хүн эх орондоо, бүс нутагтаа эргэж очсон явдал аж. 1997 онд Луксорт гадаадын жуулчдын эсрэг аллага үйлдсэн Лалын жамаат Египетэд офисоо олон газар нээлээ. “Жүүдүүд, загалмайтнуудын эсрэг ариун дайны олон улсын лалын фронт”-д (Аль-Жабха аль-алямийя аль-Исламийя ли-ль-джихад дидд-аль-яхуд ва-с-салибийин) Лалын жамаат-ын олон дайчид тулалдаж явсан, тулалдсаар байна⁵.

Исламистуудыг Израиль л бодитой үнэлнэ

“Арабын хавар”-г өөдрөг бусаар хандаж, болзошгүй ажиллагаанд бэлтгэж буй нэг улс үндэстэн Ойрхи Дорнодод байна. Энэ бол арабчуудын мөнхийн хөрш, өмнө нь 6 удаа араб хөршүүдтэйгээ дайтаж байсан Израиль Улс юм. Египетийн ардчилсан анхны сонгуулийг угтаж Израилийн цэрэг-улс төрийн удирдлага тусгай зөвлөлгөөн зохион байгуулж, Египеттэй мөргөлдөхөд тун ойртоод буй тухай таамаглан ярилцсаныг дор эшлэх нь зүйтэй гэж үзлээ. Энд яригдсан хэлэгдсэн санал дүгнэлт өнөөдөр улам бүр нотлогдож байгаа тул засваргүй толилуулъя. Үүнд:

- “Бид Египеттэй мөргөлдөхөд тун ойрхон очоод байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй” – Батлан хамгаалахын сайд асан Бен Элиезер;

- “Энэ Арабын хавар гэдэг нь фундаменталист лалын өвөл болж хувирлаа. Үүний үр дүн нь гэвэл бүх нийтийг хамарсан дайны магадлал бодитой боллоо” – Израилийн армийн ар талын дарга генерал Э.Айзенберг;

- “Арабын дарангуйлагч нар ээлж дараалан унах нь гарцаагүй боллоо. Харин тэглээ гээд арабын өвөл удтал үргэлжилж таарлаа” – Батлан хамгаалахын сайд асан МошеАренс;

- “Хахуульд идэгдсэн дампуурсан арабын дарангуйлагчдыг халж гарч ирсэн Засгийн газруудтай хэл амаа ололцоход тун бэрх, хянаж хүчрэгдэхгүй” – хэмээн Гадаад хэргийн сайд А.Либерман нар тэрхүү зөвлөлгөөн дээр хэлж, анхааруулжээ⁶.

Радикал исламистууд Египетийн сонгуульд ялалт байгуулна гэдгийг Израилийн цэргийн тагнуулын алба бүр өмнө нь судлаад дүгнэлтээ гаргачихсан байсан, дараагийн шатанд Сири дэх хэрэг явдлыг тандаж байна хэмээн Батлан хамгаалахын сайд Эхуд Барак мөн тэр үеэр ярьсан юм. Тэр тандалтаар бол: Ерөнхийлагч Башар Асадын дэглэм унах нь тэдний цаадах ираны ивээн тэтгэгчдэд хүнд цохилт болж, Сири ба шиитийн “Хэзболла”-гийн холбоо сүлбээг сулруулна хэмээн израильчууд үзжээ. Гэвч нөгөө талаасаа Сирид засгийн эрх эзгүйрсэн сул орон зай дараа нь юу болох бол гэдэгт

бүр ч ихээр сэтгэл түгшжээ. Байдал ноштой болж ирэх магадлалтай тул ерөнхий боловсролын бүх сургуульд араб хэлийг заавал сургах хөтөлбөрт шилжихийг “Балад” хэмээх намаас Кнессетэд сонгогдсон депутат хатагтай Ханин Зуаби уриалсныг бас мэдээлж байв.

Египетийн сонгуулийн хоёр дахь өдөр буюу 2011.11.29-нд Израилийн Засгийн газар яаралтай цугларч, армийн Жанжин штабын дарга Бени Ганц, цэргийн тагнуулын дарга Авив Кохави нарыг дуудаж сонсголыг нь авч хэлэлцжээ. Генерал Кохавийн илтгэснээс үзвэл, Египетийн хувьсгалт үймээний дараа исламистуудын нэр хүнд улам бэхжиж, хэрэв тэд тэр нэр хүндээрээ тус оронд засгийн эрх авбал Синайн хойг хяналтаас бүрэн алдагдах болно гэж үзжээ. Үүнтэй холбоотойгоор Израиль Улс батлан хамгаалах бодлогоо бүхэлд нь эргэж авч үзэх, тэгэх тусмаа Египеттэй залгаа хил дагуу цэргийн нэмэлт хүч татаж байрлуулах хэрэгтэй хэмээн Кохави ярьжээ. Египеттэй залгаа хил дагуу хаалт хашлага барьж байгаа нь чухам оносон алхам бөгөөд 2013 онд дуусгахаар төлөвлөснөө хугацааг нааш нь татахаас аргагүй боллоо хэмээн Жанжин штабын дарга нь хэлж байв⁷.

Ерөнхий сайд Беньямин Нетанияху Кнессетийн чуулган дээр мэдэгдэл хийж, Арабын дараалсан хувьсгалуудыг дэмжсэн барууны улс төрчдийг ширүүн шүүмжилжээ. Х.Мубаракийн талд зогсоогүй нь маш том алдаа боллоо, бодит байдлыг олж харсангүй, буруу алхам хийлээ хэмээн АНУ-ын Ерөнхийлөгчийн нэр дээр тэрээр шүүмжлэл тавьжээ.

- “Арабын хавар” гэдэг нь явж явж барууны эсрэг, либерализмын эсрэг, израилийн эсрэг, ардчиллын эсрэг лалын популист үймээн болж хувирлаа. Эдгээр хувсгал нь арабын ертөнцийг урагш нь биш, харин гэдрэг нь ухраана. Тийм учраас зөв үйл хэрэг гэж үзэх аргагүй. Хөрш Иорданд Хашемитын династ унавал том аюул учирна. Унах магадлал бий. Арабын орнуудын оршин суугчид хэвийн ардчилсан тогтолцоогоо бүтээж босгож чадна гэдэгт би үнэхээр эргэлзэж байна⁸ хэмээн Нетанияху ярьжээ.

Америкийн идеализм сөхрөх үү?

Арабын хавар-ыг анхнаас нь дэмжин дэвэргэж өөгшүүлсэн АНУ, баруун европынхны идеалист, прагматик бодлого, тэс өөр шашин-соёл, иргэшлийг ардчиллаараа амарчилж ойлгодог тэр шалтгаан нь явж явж энэ хямралын цаад шалтгаан юм. Б.Обамагийн мэдэгдлээс эшлэн түүнд өгсөн тайлбараа энд эшлэхээс аргагүй болж байна.

- Бидний дохио сануулга тун энгийн. Хэрэв Та бүхэн

реформ хийх эрсдэл, үүргийг өөртөө хүлээж л байгаа бол АНУ-ын дэмжлэгийг бүрэн хүлээнэ.

- Бид бүх бүс нутаг дахь иргэний нийгмийг дэмжих болно. Гашуун үнэнийг хэлээд албан ёсны эрх баригчиддаа мєрдөгдөж хавчигдаж байгаа төлөөлөгчдийг оролцуулан иргэний бүх нийгмийг нь бид дэмжинэ.

- АНУ бүс нутгийн орнуудын эдийн засгийн бүтээн байгуулалтыг нь дэмжих замаар иргэдийн үндсэн эрхийг хөгжүүлж, мэдээлэл чөлөөтэй хүртэх эрхийг нь дэмжинэ. Мэдээллийн эрх чөлөө бол орчин үеийн нийгмийн салшгүй эд эс нь, XXI зуунд мэдээлэл бол засаглал мөн. Үнэн бол ямагт ил байх ёстой⁹ гэж Обама айлдсан юм.

Обамагийн энэ хэдхэн үг Ойрхи Дорнодын улс төрийн үйл явцын үндсэн чигийг зааж өгсөн бол америкийн идеализм-ыг халуун тогоонд нь ажиглалт хийж суусан хүний хувьд би өөр өнцгөөс харж байна.

- Боссон тэмцсэн бүхэн ардчилал, эрх чөлөөний төлөө байдаг гэх идеализм. Лалын ертөнцөд үүнийг хэн нотолсон юм бэ?

- Лалын шашны олон зан зүйл, ёс зүй нь ардчилал, хүний эрхийн үндсэн зарчмуудтай зөрчилдөнө. Жендерийн тэгш байдал, хувь хүний эрх, хувь хүний хөгжиж дэвжих эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь лалын олон зарчмуудаар хязгаарлагдана, үүнийг олж харахыг яагаад үл хүснэ вэ?

- Боссон тэмцсэн бүхнийг зөвхөн ардчиллын үнэт зүйл гэдгээрээ харахыг хүсдэг идеализм; үүнийгээ лалын ертөнц дээр бодитой олж хараасай гэж хүсч байна¹⁰.

Тэмдэглэлийнхээ сүүлчийн мөрүүдийг хатагтай Хиллари Клинтоны алдарт афоризмаар төгсгөө!

- Өнөөдөр Египет босч ирлээ! Дэлхий дахины өлгий Египет орон эдүгээ ардчиллын өлгий боллоо!¹¹

Минийхээр бол: Өлгий болтлоо даан ч удна, хувьсгал дуусахгүй, бүх юм дөнгөж эхэлж байна!

Шашнаараа зааглахуй

Дэлхийн улс төрийн газрын зураг дээрх хил хүйтэн дайны дараах өнөө цагт соёл, угсаатан, шашны болон иргэншил хсэрондын хил болж хувирсан. Шашин-соёлоо даган дэлхийн бодлого дахин шинэчлэгдэж байна. Ижил соёлтой (шашин) улс түмнүүд нэгдэн нягтарч, ондоо соёлтой хэсэг нь бие биеэсээ зааглан холдсоор байна. Үзэл суртал ба их гүрнүүдийн харилцаа, үзэмжээр эвсэн нэгддэг үе өнгөрч, соёл ба иргэншлээрээ нэгдэн нийлэх үйл явц түүнийг орлож буй. Иргэншил хоорондын энэ шинэ зааг дэлхийн

бодлого дахь мөргөлдөөний торгон шугам болжээ. Америк эрдэмтэн С.Хантингтоны эл онол¹² шинэ XXI зууны эхний энэ 10 гаран жилд алхам тутамд нотлогдож байгаагийн салаа салбар нь Арабын хувьсгалаар өндийж ирсэн исламистууд, жихадистууд, салафитууд тул энд шууд буруутгах аргагүй. Нэгэнт л иргэншлээрээ (шашнаараа) нэгдэн нийлэх үйл явц олон улсын харилцаанд бодит зүй тогтол болж буй учраас шинээр төлөвших салафизм, ваххабизм ба түүнийг хүлээн авагч мусульманчуудад ял тохохыг энд зориогүй болно.

Тэгэхдээ хариулж үл хүчрэх хэд хэдэн асуудал хариултаа хүлээж байх шиг. Лалын иргэншийн цөм улс болохыг илтээр хүсч тэмүүлж буй Саудын Арабын ваххабизм пост- дарангуйллын Арабын хөрсөн дээр хэр буух вэ? Түүнийг тээгч нь хэн бэ? Арабын хувьсгалын зарим удирдагчид ваххабизм, салафизмыг туйлшруулж хүлээн авч, туйлшруулж нэвтрүүлэхийг зорьж эхэлж буйд учир байх аж. Тэд юуны өмнө (1) жихадыг нэлэнхүйд нь нэвтрүүлэхийг зорьж, зарим талаар террор үйлдэж байна; (2) “Цэвэр лал” хэмээн туйлширсан. Тэр “цэвэр лал” нь халифатын хэлбэрээр оршин тогтнох учраас уламжлалт төрийн байгуулалт, институцилалын өөдөөс сөргүүллээ; (3) Нэгэнт тэгж туйлширсан учраас “үл итгэгчдийнхээ” эсрэг эвлэршгүй тэмцэл эхлүүлсэн; (4) ваххабизм, салафизмыг улс төрийн өрсөлдөгчдийнхөө эсрэг геополитикийн сөргөлдөөний зэвсэг болгосон; (5) эл тэмцэл нь олон түмнийг хамрах шинжтэй болсон гэж үзэж болно. Суннит лалын ваххабизм нь шашнаараа нэгдэн нийлэх, “лалчлагдах” дэлхий дахины нийтлэг үзэгдлийн нэг хэсэг, тусгал нь гэдгийг энд тооцох учиртай. Нэгэнт дэлхийн нийтийн үзэгдэл гэдэг утгаар авч үзвэл, Арабын ертөнцийн орон зайд хамгийн хүчтэй нэвтэрсэн олон улсын лалын институци хэмээн гэж нэр заахаар хүчтэй тоглогчид гарч ирээд байгаа нь энэ авай.

Цаашдын төлөв

Араб дахь тэмцэл хөдөлгөөн, мөргөлдөөн намжих уу, эсвэл шатлан өргөжих үү? Ойн түймрийг мөлдөө унтрааж дөнгөдөггүй, сайндаа л цурманд оруулдаг гэдэг шиг Араб ертөнцөд дэгдсэн энэ үйл явцыг ойн түймэртэй зүйрлүүлж болох талтай. Арабын ертөнц реформыг олон жил хүлээсэн, шаардсан, дэглэмүүд нь үүнийг хүсээгүй, хүсээгүйгээс үүдээд тэсрэлт гарч, тэр нь түймэр болж даамжирсан, түймрийг унтраатал хол байна.

Ямар ч атугай энэ их хувьсгалт үйл явцын үр дүнд салафитуудын халифат түүхнээ сэргэлээ. Энэ нь цаашаа “лалын эмират”, “шариатын бүс” болж салбарлан отог омог, хот тосгод, хотын хорооллуудаар тархах магадлалтай. Өөрөөр хэлбэл төр улсын дотор салафитуудын

анклавууд үүснэ. Төрөөс хяналт тавьж чадахгүй болно. Хянагдахгүй бүсүүд үүснэ. Энд шариатаас өөр ямар ч хууль үйлчлэхгүй¹³.

Салафитуудын халифат гэгч нь өмнө нь Афганистанд буй болгоод амьдралаар шалгаруулчихсан. Карзайн төр улсаас гадна “Афганистаны лалын эмират” гэгч нэг улс улсын дотор улс болоод байж байна. 2011 оны зун Ливид “Лалын Магрибын орнууд дахь Аль-Каида-ын” хяналт доорхи лалын эмират буй болж байсан. Бенгази, Дерна, Эль-Бейда, Эль-Мараж, Шихат зэрэг хотод тийм эмиратуудыг зарлан тунхагласан. Йеменд “Арабчуудын арал дээрхи Аль-Каида-ын” хяналт доорхи эмиратууд Зинжибар, Аззан, Жиар, Ридаа хот, Абиян, Шабва, Хадрамаут мужид байгуулагдсан. Тунист Бизерт хотын ойролцоох тосгодын лалын эмират гэж зарласан. Сомалид “Шабеллын лалын эмират” одоо оршин байна. Малид “Лалын Тимбукту эмират” гэгчийг зарлаад тус улсыг хоёр хуваах дээрээ тулсан. Палестинд Жунд Ансар Аллах гэгчийн дайчид 2009 онд Рафах хотод лалын эмиратаа байгуулсан. Тэднийг ХАМАС-ын эрх баригчид өөрсдөө устгаж аюулыг нь зайлуулсан боловч бүрмөсөн дарж чадаагүй байна. Сирийн дотоодын дайнтай холбогдуулан зарим нутгийг таслаж эмират болгох хөдөлгөөн аль эрт эхлээд байна. Иорданы Эз-Зарка хотод de facto оршин буй лалын эмиратын дэмжлэгээр Сирийн Дераа хот, Бинниш хот салафитын анклав болоход ойрхон буй. Эцэст нь Каирт Имбаба гэх хорооллыг салафитын лалын эмират гэж зарлаад тэнд христианчуудын эсрэг халдлага үе үе үйлдэж байгаа гэхчлэн жишээ баримт дэндүү их аж.

Энэ бүхэн явж явж Саудын Араб, Катараас санхүүжсэн, салафитын гурвалжинг үүсгэж, тэр нь Ойрхи Дорнод, Дундад Дорнодод хүчирхэгжин, улмаар Ираны шиизм, Израилийн жүудаизмын эсрэг шашны ариун дайн руу турхирах юм биш байгаа гэх таамаглал ч цухалзаж байна. Саудын Араб, Катар хоёр Сирийн дотоодын хэрэг явдалд үлэмж оролцож, геополитикийн тоглолт хийж эхлээд байгааг гадаадын хэвлэлд нэгэнтээ дурдаж тэмдэглэж байна. Ваххабизм буюу салафизм нь газрын тос, байгалийн хийн асар их баялагтай Булангийн энэ хоёр улсын төрийн албан ёсны шашин хэмээн хуульчлагдсан, тэр утгаараа дэглэм нурсны дараа онгойсон улс төрийн сул орон зайд (хүчирхэг Египет илт суларсан) голлох үүрэгтэй болж байгаа ажээ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ Баабар, Баярхүү. Ертөнцийн шинэхэн түүхийг бүтээгчид, Непко хэвлэлийн газар, 2012, 422-430 дахь талд

² ABC News, 05.02.2011

³ Al Jamahirya, Al Hidayah, Al Shababya, 22.02.2011

⁴ Д.Баярхүү. “Арабын хавар”-аас “Лалын өвөл” рүү шилжих хувьсгал, “Стратеги судлал” □ 60 (4/2012)

⁵ Мөн тэнд

⁶ Los nervios y la incertidumbre de Israel ante ‘un largo invierno’, El Mundo, 23.11. () авч тавьсан.

⁷ Yediot Ajaronotv.com, ynetnews.com, haaretzdaily.com, 7kanal.com зэрэг израилийн сайтуудын 2011 оны 11 дүгээр сарын зарим мэдээнээс

⁸ Netanyahu: Arab Spring pushing Mideast backward, not forward, Haaretzdaily.com, 24.11.2011

⁹ Euronews.net, 19.05.2011

¹⁰ Д.Баярхүү. Тахрирын хувьсгал (нэмж завсарласан 2 дахь хэвлэл) Непко хэвлэлийн газар, 2013, 551 дэх тал

¹¹ Associated Press, Nile TV, 16.03.2011

¹² Самуэль Хантингтон. Иргэншил хоорондын мөргөлдөөн: Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам (Samuel P.Huntington. The Clash of Civilizations and the Remaking of World Order, Touchstone Books, London, 1997), ННХ, Монсудар, 2005

¹³ Д.Баярхүү. “Арабын хавар”-аас “Лалын өвөл” рүү шилжих хувьсгал, “Стратеги судлал” □ 60 (4/2012)

Abstract

The Middle East, Arab World have admired the world for 2011. Ben Ali, Mubarak, Kaddafi, Asadin, Saleh regimes were collapsed. The political and economic reform was not conducted in a history of monarchy countries in Arabia and Persain, multiparty system was not formed (some even have no ideas). As a result the regime failed and what should do in the future, the admiration, if political space will open might continue not only for one or two years but for years.